

74



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 3/4

Номгон

Цар тахлын үеэр аймгийн Онцгой комисст хандив тусламж үзүүлсэн ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд талархал илэрхийлж сайшаан, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Коронавирусын халдвараас иргэд олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ болон халдварт өвчний нөхцөл байдал, мөн орон нутагт тохиолдсон өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг эрсдэл багатай даван туулах арга хэмжээнүүдийг өндөр түвшинд зохион байгуулж байгаа аймгийн Онцгой комиссын үйл ажиллагаанд эдийн засгийн хүндрэлтэй энэ цаг үед хандив тусламж үзүүлсэн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад талархал илэрхийлсүгэй.

2. Хандив тусламжийг коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, шаардлагатай арга хэмжээнд холбогдох дүрэм, журмын дагуу зарцуулж ажилласан аймгийн Онцгой комисс (Д.Мөнхсайхан)-ыг сайшаасугай.

3. Бусад эх үүсвэрээс нэмж хуваарилсан 770,297,000 (Долоон зуун далан сая хоёр зуун ерэн долоон мянган) төгрөгийг хавсралтын дагуу эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай яаралтай түргэн тусламжийн автомашин, эм тариа, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд холбогдох хууль журмын дагуу зарцуулж ажиллахыг аймгийн Онцгой комиссын Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, зарцуулах ажлын хэсэг (С.Байгалмаа), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов) нарт үүрэг болгосугай.


4. Цаашид хандив тусламжийн зарцуулалтын тайлан мэдээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны сайт, цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд

1200036


түгээж ажиллахыг аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (Э.Батбаяр)-д даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит
III хуралдааны 3/4 дүгээр тогтролын хавсралт



КОВИДЫН ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД
НЭН ШААРДЛАГАТАЙ БАЙГАА ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,
ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Эмнэлгийн тоног төхөөрөмж					
1	Дуслын автомат шахуурга	ширхэг	10	2,400,000	24,000,000
2	Амьсгал дэмжих аппарат СРАР	ширхэг	5	3,000,000	15,000,000
3	Амьсгалын аппарат	ширхэг	3	27,000,000	81,000,000
4	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	ширхэг	20	1,500,000	30,000,000
5	Тарианы шахуурга	ширхэг	10	1,800,000	18,000,000
6	Бобров	ширхэг	20	500,000	10,000,000
7	Хүчилтөрөгчийн редуктор	ширхэг	20	250,000	5,000,000
8	ХОЛТЕР ЭКГ	ширхэг	1	5,000,000	5,000,000
9	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	ширхэг	1	5,500,000	5,500,000
10	Хяналтын монитор	ширхэг	20	3,000,000	60,000,000
	Дүн				253,500,000
Эм, тариа					
10	Левифлоксацин тариагаар	флакон	1900	6,000	11,400,000
11	Ремидесивир тариагаар	флакон	750	149,600	112,200,000
12	Арбидол	ширхэг	20000	1,800	36,000,000
13	Фавипириривир	ширхэг	2000	4,500	9,000,000
14	АЦЦ 200 мг	ширхэг	10000	500	5,000,000
15	Меропенем 1гр	флакон	200	33,000	6,600,000
16	Амоксиклав 1.2гр	флакон	3000	4,200	12,600,000
17	Цефтазидим 1гр	флакон	500	1,200	600,000
	Дүн				193,400,000
Ор дэлгэх					
18	Гудас, хөнжил, ком	ширхэг	100	31,000	3,100,000
19	Эмнэлгийн зориулалттай угаалгын машин	ширхэг	1	50,000,000	50,000,000
	Дүн				53,100,000
	Нийт дүн				500,000,000